



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/426

Улаанбаатар хот

「 Баянгол дүүргийн 100 дугаар цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,392,000.00 (нэг сая гурван зуун ерөн хоёр мянган) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу тухайн байгууллагын балансад шилжүүлэн данс бүртгэлээс хасахыг Баянгол 100 дугаар цэцэрлэг (Ц.Дэлгэрмаа)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 5 дугаар сургууль (Н.Гэндэнсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 100 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Үзүүлэлт	Ашиглал- тад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагд-сан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Аяга таваг угаагч, ариутгагч машин	Хятад	2022.10.13	ш	1	1,392,000.00	1,392,000.00	278,400.00	1,113,600.00	Нийслэлийн ерөнхий боловсролын 5 дугаар сургууль
	Машин, тоног төхөөрөмжийн дүн						1,392,000.00	278,400.00	1,113,600.00	
	Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн						1,392,000.00	278,400.00	1,113,600.00	